

Төв Азийн Залуу Бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр (CA YIB) – Транскапитал ББСБ-ын Залуу бизнес эрхлэгчийг дэмжих зээл I

Орон:	МОНГОЛ УЛС
Төслийн дугаар:	54313
Бизнесийн салбар:	Банк санхүү (банк бус)
Мэдэгдлийн төрөл:	ХУВИЙН ХЭВШИЛ
Байгаль орчны ангилал:	Санхүүгийн зуучлал (FI)
Төсөл батлах төлөвлөгөөт огноо:	2023 оны 8 дугаар сарын 8
Төлөв байдал:	Баталсан
Төслийн хураангуйг Англи хэлээр танилцуулсан огноо:	2023 оны 8 дугаар сарын 14

Төслийн танилцуулга

Санхүүгийн зуучлалын суурь хөтөлбөр (FIF)-ний "Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр (YIB CA)-ийн хүрээнд Транскапитал ББСБ ХХК-д олгох 4 сая хүртэлх ам.долларын (төгрөгөөр олгох) анхдагч өглөгт тооцогдох барьцаагүй зээл олгох.

Төслийн зорилго

Банкны санхүүжилтийг Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийн Бодлогын мэдэгдэлд заасан шалгууруудын дагуу 35 нас хүртэлх залуучуудаар толгойлсон, шаардлага хангах бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд ("Залуучуудын БЖДҮ")-эд дамжуулан зээлдүүлэхэд ашиглана.

Зээлийн хөрөнгийн 10 хүртэлх хувийг Ногоон эдийн засгийн шилжилт (НЭЗШ)-ийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтад зарцуулна. Транскапитал нь техник тусламж авах бөгөөд Монголын Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх хөтөлбөрийн хүрээнд үнэлгээ хийлгэх, технологийн шаардлага хангах аргачлалыг ашиглана.

Дээр нь, Транскапитал 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-т хамрагдсан оролцогчдыг хүйсээр нь ялган бүртгэлжүүлэх бөгөөд дамжуулан зээлдэгчдийн дор хаяж 30% нь эмэгтэйчүүд байхыг хангах үүрэг хүлээсэн болно.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл: 71

Тус төсөл нь 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-ийн хүрээнд Монголд хэрэгжих анхны зээл бөгөөд Хөтөлбөрийн хүртээмжтэй, өрсөлдөх чадварууд бүхий чанаруудыг дэмжиж ажиллах юм.

Төсөл нь Монгол дахь залуучуудад олгох зээлийг нэмэгдүүлж, Транскапиталын чадавхийг сайжруулан, тус орны бизнес эзэмшигч, удирдагч залуучуудад ур чадвар дамжуулан суулгах явдлыг урашглуулна гэсэн хүлээлт байгаа.

Харилцагчийн мэдээлэл

ТРАНСКАПИТАЛ ББСБ ХХК

2001 онд байгуулагдсан Транскапитал ББСБ ХХК (ТКМН) нь Монголын гуравдахь том банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) бөгөөд 2013 оноос ЕСБХБ-ны харилцагч болсон.

Тус компани Улаанбаатар хот (19 салбар), хөдөөгийн 16 аймаг (19 салбар) дахь БЖДҮ, өрхүүд, хувь хүмүүст зээл олгодог.

ЕСБХБ-ны санхүүжилтийн товч мэдээлэл

4,000,000.00 ам.доллар

ЕСБХБ-ны санхүүжилт 4.0 сая ам.доллар

Төслийн нийт өртөг

4,000,000.00 ам.доллар

Байгаль орчин, нийгмийн шаардлагын тойм

Санхүүгийн зуучлал (2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого баримт бичиг). ТКМН нь Банкны харилцагч бөгөөд ЕСБХБ-ны Байгаль орчин, тогтвортой байдлын газар (ESD) тус компани дээр ажиллаж, тэдний төслийн судалгаа, үнэлгээний процесс, зээлийн багцийн нийтлэг шинж чанар, хяналт шалгалтын аргачлалыг нь нягтлан шалгасан болно. Компани ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) 9-д нийцсэн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгэм (EHSS)-ийн эрсдлийн менежментийн журмуудтай бөгөөд мөн өөрсдийн ажиллагсдын хувьд ГШ 2, ГШ 4-д нийцсэн хөдөлмөрийн болоод хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны журмыг баримталдаг байна. Тэд ЕСБХБ-тай харилцаж байсан хугацааны туршид шаардлагын дагуу ажлаа тайлагнаж ирсэн бөгөөд тус хугацаанд шаардлагатай процесс, процедурыг баримтлан ажилладаг байсан. Тус компани санал болгож буй зээлийн хувьд шаардлагатай ГШ-ууд, мөн

компани, ЖДҮ, бичил зээлийн талаарх Банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгэм (EHSS)-ийн журмыг ханган ажиллах юм.

Санхүүгийн зуучлалын суурь хөтөлбөрийн 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-т зээлийн зарцуулалтын зориулалтыг тодорхойлсон бөгөөд тэдгээр нь Банкны шууд бус санхүүжүүлэлтийг Парисын хэлэлцээрт нийцүүлэх аргачлалын хүрээнд Парисийн Хэлэлцээрт нийцэж байгаа. Төсөл нь НЭЗШ-ийн хандлагатай нийцэж байгаа бөгөөд НЭЗШ-ийн хувь хэмжээ нь 10% байх юм.

Техник хамтын ажиллагаа

А. Техник хамтын ажиллагаа (ТХА): Төв Ази дахь санхүүгийн бүх оролцогч түнш байгууллага (СТБ)-тай хөтөлбөрийн түвшинд хэрэгжүүлэх ТХА.

Санхүүгийн зуучлалын суурь хөтөлбөрийн 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-ийн ТХА нь дараах хоёр хоорондоо хамааралтай хэсгээс бүрдэнэ:

(i) *СТБ-уудын онцлогт тохируулсан чадавхи сайжруулах бүрэлдэхүүн хэсэг.* Санхүүжилтийн эх үүсвэр: Хувь эзэмшигчдийн тусгай сан, бусад хандивлагчид. 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-ийн түвшинд 4 сая евро, туршилтын шатанд 1.2 сая евро. Санхүүжилтийн төлөв байдал: Туршилтын шатны хувьд баталгаажсан.

(ii) *Зөвлөх Үйлчилгээ Хөтөлбөр (ASB)-өөр дамжуулан Залуучуудын БЖДҮ-үүдийн чадавхи бий болгох.* Санхүүжилтийн эх үүсвэр: Хувь эзэмшигчдийн тусгай сан, бусад хандивлагчид. Хэмжээ/валют: 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-ийн түвшинд 6 сая евро, туршилтын шатанд 1.5 сая евро. Санхүүжилтийн төлөв байдал: Туршилтын шатны хувьд баталгаажсан.

НЭЗШ-д холбогдох ТХА: Монголын Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх хөтөлбөрийн хүрээнд, ЕСБХБ-ны Хувь эзэмшигчдийн тусгай сан болон Япон-ЕСБХБ-ны Хамтын ажиллагааны сангаас. Энэ хамтын ажиллагааны гол зорилго нь НЭЗШ-ийн шалгууруудад нийцсэн хөрөнгө оруулалтуудад үнэлгээ өгөх, тайлан гаргах ажил байх юм.

В. Хамтын буцалтгүй тусламж / Хөнгөлөлттэй санхүүжилт (ТХА-ны бус)

Тус төсөлд дараахь багтана:

- Анхдагч алдагдлын эрсдлийн даатгалын механизм - 'Бизнес дэх залуучууд' зээлийн 7 хүртэлх хувь (нэг дэд зээлийн хувьд 70%-иар хязгаарлана); анхдагч алдагдлын эрсдлийн даатгал нь 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр'-т оролцсоны улмаас ТКМН-д учирсан зээлийн алдагдлыг нөхөн олгоно.
- Гүйцэтгэлд суурилсан нөхөн олговор (ГСНО) – санал болгож буй 'Бизнес дэх залуучууд' зээлийн 3 хүртэлх хувь; ГСНО нь 'Бизнес дэх залуучууд' зээлийг тогтвортой өргөжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц бий болгохтой холбогдсон урьдчилсан хөрөнгө оруулалт хийсэн бол ТКМН-д хэсэгчлэн нөхөн олговор олгох боломж юм.

Санхүүжилтийн эх үүсвэр: Хувь эзэмшигчдийн тусгай сан, бусад хандивлагчид. Тоо хэмжээ/валют: нийт 360,000 евро (эсвэл, санал болгож буй 'Бизнес дэх залуучууд' зээлийн 10%). Санхүүжилтийн төлөв байдал: Баталгаажсан.

ТХА-ны бус: 12.5%-ийн анхдагч алдагдлын баталгааны хөрөнгийг ЖДҮ-ийн дотоод валютын тусгай сангаас гаргаж, анхдагч алдагдлыг санхүүжүүлэхэд нь зориулан ЕСБХБ-нд олгоно.

Нэмэлт ашиг тус

Санхүүжилтийн шинэлэг бүтэц ба/эсвэл шинэлэг хэрэгсэл: Тус төсөл Төв Азийн зах зээлд тохируулсан, шинэлэг хэрэгсэл болох Анхдагч алдагдлын эрсдлийн даатгал (ААЭД), Гүйцэтгэлд суурилсан нөхөн олговор (ГСНО) тус бүрээс ашиг тус хүртэнэ.

Санхүүжилтийн бүтэц: ЕСБХБ нь зах зээл дээр тийм ч амар олдохгүй нөхцлөөр дотоод валютын санхүүжилт олгож байна.

Стандарт тогтоох: 'Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр' нь бүрэлдэхүүн хэсгүүд (санхүүжилт, ААЭД, ГСНО, ТХА)-ийг хамтатган ашиглах замаар залуу энтрепренерүүдийн орхигдонгүй байгаа хэсгийн хэрэгцээг илүү сайн мэдэрч ойлгох явдлыг нэмэгдүүлж, улмаар өөрийн хүртээмжтэй санхүүжилтийн стандартыг сайжруулахад нь ТКМН-д тус дэм болох юм. ТХА-ны иж бүрэн багц нь бүтээгдэхүүн, түүнийг хүргэх механизмаа залуу энтрепренерүүдийн хэрэгцээнд илүү тохируулан сайжруулахад нь СТБ-уудад дэмжлэг үзүүлнэ. Ингэснээр, залуу энтрепренерүүдийн тухайн хэсгийн потенциалыг ашиглах, өөрийн санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэх боломж ТКМН-д олгох юм.

Жендэрийн хувьд ухаалаг: Монголын залуу энтрепренерүүд дотор оршсоор байгаа жендэрийн тэнцвэргүй байдлын асуудлыг ТКМН-д үзүүлэх ТХА-ны зориулалтын тусламжаар шийдвэрлэхийг зорих бөгөөд энэ нь залуучуудыг онилсон зээлд жендэрийн хувьд хариуцлагатай хандах хандлагыг хөгжүүлэх, улмаар залуучуудад хандахдаа залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн аль алиныг нь авч үзэх явдлыг хангах юм.

Мэдлэг, инновац ба чадавхи бий болгох: Тус хөтөлбөрт чадавхи бүрдүүлэх өргөн хүрээний арга хэмжээнүүд орж байгаа бөгөөд үүнд Зөвлөх Үйлчилгээ Хөтөлбөр (ASB)-ийн хүрээнд сургалт явуулах, СТБ-ууд болон Залуучуудын БЖДҮ-үүдэд зөвлөгөө өгөх, НЭЗШ-ийн санхүүжилттэй холбогдолтой техник тусламж үзүүлэх зэрэг багтаж байна. Ингэснээр, дотоодын зах зээл дээр байхгүй байж болох мэдлэг, мэргэжлийн туршлагаас суралцах, ашиг тусыг нь хүртэх боломжийг нийт оролцогч талуудад олгох болно.

Компаний холбоо барих мэдээлэл

Х. Хонгорзул

khongorzul.kh@transcapital.mn

+976 18001600

Транскапитал байр, Партизаны
гудамж, Сухбаатар дүүрэг, 4 дүгээр
хороо

Улаанбаатар 14250, Монгол Улс

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн

сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алианаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.